



УЛААНБААТАР ХОТЫН
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
ОНӨААТҮГ

Токиогийн 5 дугаар гудамж, 3 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976) 7015 7015
Цахим шуудан: usug1959@gmail.com
Цахим хуудас: www.usug.ub.gov.mn

2024.05.27 № 6/1473

танай _____-ны № _____-т

Тодруулга

"А" ХХКомпани нь манай байгууллагаас зарласан "Багаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ үзүүлэх нэртэй, УСУГ/20240103028 дугаартай тендерийн Багц-3 Лабораторийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ үзүүлэх төсөвт өртгийн талаар нэмэлт тодруулга авах тухай хүсэлт цахим системээр ирүүлсэн байна. Үүнд:

Тус тендерийн Багц-3 Лабораторийн тоног төхөөрөмжүүдийн үзлэг шалгалт, засвар үйлчилгээнд 57 нэр төрлийн 151 ширхэг аппаратууд багтаж байгаа бөгөөд төсөвт өртөг нь 24,000,000 төгрөг гэж заажээ. Энэ төсөвт үзлэг шалгалт, засвар үйлчилгээний үнээс гадна сэлбэг хэрэгсэл, шаардлагатай тохиолдолд сэлбэгийн үнийг багтаан тооцсон эсэхийг тодруулж өгнө үү.

Тодруулга:

Лабораторийн тоног төхөөрөмжийн үзлэг шалгалт, засвар үйлчилгээнд 57 нэр төрлийн 151 ширхэг багажууд багтаж байгаа бөгөөд төсөвт өртөг нь 24,000,000 төгрөг байх ба 12 сарын хугацаанд сар бүр үзлэг шалгалт хийж эвдрэл гэмтэл гарсан үед шаардлагатай сэлбэг, барааг энэ төсвөөс гаргахаар тооцсон болохыг үүгээр мэдэгдэж байна.